

“ТҮШИГ-УУЛ” ХК –ний хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл

2022.04.29

Дархан хот

Ээлжит хурал 2022 оны 04 дүгээр сарын 29-нд Дархан Уул аймаг Дархан сум 3-р баг өөрийн байранд болов.

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэв.

Хуралд :

1. Ж.Баяраа /рд: ТЖ62062018/ 830800 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 19,1 %
2. Ж.Батсайхан /рд: ТВ71041516/ 869120 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 20,0 %
3. Ж.Баянтөр /рд: ТВ64012611/ 869050 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 20,0 %
4. Л.Ганчимэг /рд: ТЕ61032565/ 868030 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 20,0 %

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэтуяа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 3437000 ширхэг хувьцаа эзэмшдэг 4 хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр хуралд оролцохоор ирсэнг бүртгэв.

Хурлын дарга Ж.Батсайхан: за өнөөдөр хуралд ирсэн та нарт энэ өдрийн мэндийг хүргэс. Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулна. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн тул хурлаа эхлэе.

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэтуяа ирц танилцуулан тооллогын комиссын тогтоол танилцуулав.

Нийт саналын эрх бүхий элгийн хувьцааны 79,1 хувь болж байгааг Хурлын даргад мэдээлж хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компаний тухай хуулийн 69,1 дэх хэсгийг үндэслэн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцон, тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дарга: Ж.Батсайхан

Хурлаар хэлэлцэх асуудал бол 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах мөн цаашдын үйл ажиллагааны талаар хэлэлцэнэ.

2021 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав /тайланг хавсаргав/

Тайлантай холбоотой санал асуулга:

Ж.Баянтөр: : 2021 оны үйл ажиллагааны тайланг сонслоо. Цаашид ямар үйл ажиллагаа хэрхэх тухай ээлжит бус хуралдуулан хэлэлцэх хэрэгтэй гэж бодож байна. Манай үйлдвэрийн засвар үйлчилгээ гар ажиллагаа ихтэй, хүний нөөц дутмаг мөн төмөр замын засвар арчлалт, сум дэр модны үнэ зах зээлд өндөр байгаа нь жил бүр ажиглагдаж байна. Мөн үйлдвэрийн элэгдэл их, тодорхой дорвитой хөрөнгө оруулалт хийж чадахгүй байгаа нь асуудал болоод байна. Бид ашиг муу гээд үйлдвэрийн үйл ажиллагааг хаах ямарч бололцоогүй юм. Байнгын харилцагч байгууллагуудын үйл ажиллагаа ч манайхтай салшгүй холбоотой болсон. Тэгэхээр үйлдвэрийн засвар үйлчилгээг тогтмол хариуцлагатай чанартай хийж хийж бүтээгдэхүүн олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хүн хүч нэмэгдүүлэн ажиллах тал дээр санаачлагатай байх хүний нөөцийн бодлого явуулах хэрэгтэй. Ингээд 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын дүгнэлтийг батлахыг дэмжиж байна.

Ж.Баяраа: Цар тахал хэвийн ажиллахад бололцооно. Удирдлуугууд хуулийн мэдлэг мэдээлэл сайтай байхгүй бол болохгүй болжээ. Баянтөрийн хэлснээр цаашид энэ компанийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын талаар яаралтай хэлэлцэх хэрэгтэй гэж бодож байна.

Л.Ганчимэг:2021 оныхоо алдаанд дүгнэлт хийж аль болох бүтээмжээ нэмж ажиллахыг гүйцэтгэх удирдлагаас хүсье.

Ж.Батсайхан : за санал асуулга дууссан бол санал авах хуудсаар зөвшөөрсөн татгалзсан саналын тоогоор саналаа хураая.

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэтуяа: Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн санал нь компаний тухай хуулийн 63 дугаар зүйлд заасан хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох хувьд хүрсэн тухай, хурлын шийдвэрийг батлах тогтоолын төслийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Зөвшөөрсөн 3437000 ширхэг хувьцаа буюу 79,1 хувиар батлав.

Ж.Батсайхан тогтоолыг танилцуулав .

1. Тогтоол -1 . “ Түшиг-Уул “ ХК-ны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг талаарх ТУЗ-ын дүгнэлтийг баталсугай.

Хурлын дарга Ж.Батсайхан хэлэлцэх асуудал дууссан хурлыг дуусгав.

